



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 426

Улаанбаатар хот

“Монголын төмөр зам” төрийн өмчит
хувьцаат компанийн дүрэмд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны 434 дүгээр тогтоолын 3 дугаар заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 726 дугаартай тогтоолоор батлагдсан “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн дүрэмд дараах заалтуудыг нэмсүгэй.

1.1. “2.2.5. 0.4-35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх, эрчим хүчээр зохицуулалттай хангах, ”

1.2. “2.6. Гүйцэтгэх удирдлага компанийн ашиг орлого, хөдлөх бүрэлдэхүүний тоо хэмжээ, хүчин чадлыг нэмэгдүүлэх, стратеги төлөвлөгөөний зорилго, зорилтыг хангах зорилгоор төсөл хөтөлбөр, үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх гадаад, дотоодын хувь хүн, хуулийн этгээдтэй Компанийн тухай хуулийн 88 дугаар зүйлд зааснаас бусад хэлцлийг хийж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэнэ.

2.Компанийн дүрмийн заалтуудыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

2.1. “2.2. “Компани нь дор дурдсан үндсэн үйл ажиллагааг эрхэлнэ” гэснийг “Компани нь дор дурдсан үндсэн үйл ажиллагаа эрхэлж, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад үйлчилгээ үзүүлнэ.” гэж,

2.2. “2.2.1. “Төмөр замын суурь бүтэц барих, ашиглах” гэснийг “Төмөр замын суурь бүтэц барих, ашиглах, техник, технологийн хяналт тавих, зөвлөх үйлчилгээ үзүүлэх” гэж,

2.3. “2.2.2. “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүнийг угсрах, засварлах, түрээслэх, суурь бүтцийг засварлах, арчлах” гэснийг “Төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, тэдгээрийн эд анги, сэлбэг хэрэгслийг үйлдвэрлэх, угсрах, засварлах, түрээслэх, ашиглуулах,” гэж,

2.4. “2.2.3. “Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх” гэснийг “Төмөр замын тээврийн үйл ажиллагаа эрхлэх” гэж,

2.5. “2.2.4. “Төмөр замын зураг төсөл, төсөв, ТЭЗҮ боловсруулах” гэснийг “Төмөр зам, автозам, хуурай боомт, эрчим хүч, харилцаа холбоо, гүүр, хоолойн барилга байгууламжийн зураг төсөл, төсөв, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, захиалагчийн хяналт хэрэгжүүлэх,” гэж,

2.6. “8.7. “Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг зогсоох шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл хэдийд ч гаргаж болно” гэснийг “Төлөөлөн удирдах зөвлөл Гүйцэтгэх

захирлын бүрэн эрхийг түүнтэй байгуулсан Онцгой нөхцөл бүхий гэрээнд заасан үндэслэлээр зогсооно.” гэж,

2.7. “8.11.14. “Төмөр замын тээврийн тарифыг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулсны үндсэн дээр холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн батална.” гэснийг “Төмөр замын тээврийн тарифыг Төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрлийн үндсэн дээр холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн батална” гэж,

2.8. “11.5. “Компанийн дотоод хяналтыг Гүйцэтгэх захирлын томилсон дотоод хяналтын алба хэрэгжүүлнэ” гэснийг “Компанийн дотоод хяналтыг Гүйцэтгэх захирлын шууд удирдлагад дотоод хяналтын нэгж хэрэгжүүлнэ.” гэж,

2.9. “11.6. “Дотоод хяналтын алба компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг тавьж, гүйцэтгэл нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, энэхүү дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолд нийцэж байгаа эсэхийг хангаж ажиллана” гэснийг “Дотоод хяналтын нэгж холбогдох хууль тогтоомжид заасны дагуу компанийн санхүүгийн болон өдөр тутмын үйл ажиллагаанд дотоод аудит хийх, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр хяналт тавих, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод хяналт шалгалт хийх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу бүтцийн нэгж, ажилтны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.” гэж,

2.10. “11.7. “Дотоод хяналтын алба нь шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил, дутагдлыг арилгах, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн зөвлөмжийг Гүйцэтгэх захиралд өгөх, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах, мэдээлэх үүрэгтэй” гэснийг “Дотоод хяналтын нэгж компанийн хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, алдаа, зөрчил, дутагдлыг арилгах үүрэг чиглэл өгөх, хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцуулах, эрсдэлийг бууруулах санал зөвлөмжөөр Гүйцэтгэх захирлыг тухай бүр, Төлөөлөн удирдах зөвлөлийг хагас жил бүр хангаж ажиллана.” гэж,

3.Дүрэмд орсон өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Улсын бүртгэлд бүртгүүлэхийг “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (Б.Отгонсүх)-д даалгасугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

